



МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

Хөнгөлөлттэй зээл олгох ерөнхий
нөхцөл батлах тухай

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор баталсан "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 2.4, 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2024 онд хөнгөлөлттэй зээл олгох салбар, чиглэлийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2024 оны төсөвт зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс олгох хөнгөлөлттэй зээлийн зориулалтаар тусгагдсан хөрөнгөөс 29,000,000,000 (Хорин есөн тэрбум) төгрөгийг 1 дүгээр хавсралтад заасан салбар, чиглэлийн жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдийн үндсэн хөрөнгө оруулалтад зориулж, 5 жилийн хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэй сангаас шууд олгох, үндсэн зээлийн төлбөрөөс эхний 12 сар хүртэл хугацаанд чөлөөлөхөөр ерөнхий нөхцөлийг тогтоосугай.

3. Зээлийн ерөнхий нөхцөлийн хүрээнд 2024 онд сангаас шууд олгох 29,000,000,000 (Хорин есөн тэрбум) төгрөгийг аймаг, нийслэлд олгох хуваарийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

4. Батлагдсан эх үүсвэрийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлдэгчийн зээлийн эргэн төлөлтөөс шуурхай татан төвлөрүүлэх чиглэлээр бүхий л арга хэмжээ авч ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газар (Я.Эрдэнэсайхан)-т үүрэг болгосугай.

5. Төсөл, сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу ил тод шударга зохион байгуулж, мэдээллийг олон нийтэд хүргэж ажиллахыг төсөл сонгон шалгаруулах хороо, дэд хороодод мэргэжил аргагүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газар (Я.Эрдэнэсайхан)-т даалгаж, аймгийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Т.Жамбалцэрэн)-д үүрэг болгосугай.

САЙД

Х.БОЛОРЧУЛУУН

1301010063

Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн Сайдын 2024 оны
01 дүгээр сарын 15-ны өдрийн
А/18 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС 2024 ОНД
ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХ САЛБАР**

Хүнсний үйлдвэр

- Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах
- Мах, дайвар бүтээгдэхүүн боловсруулах
- Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ боловсруулах
- Гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Хүнсний зориулалтын сав, баглаа боодлын үйлдвэрлэл
- Цэвэр усны үйлдвэрлэл
- Хүүхдийн хоол, тэжээлийн үйлдвэрлэл

Газар тариалан

- Хүлэмжийн аж ахуй
- Хүнсний зоорь, агуулах
- Малын тэжээл, бордооны үйлдвэрлэл
- Агро ойн аж ахуй
- Төмс, хүнсний ногооны үр үйлдвэрлэл

Мал аж ахуй

- Эрчимжсэн мал аж ахуй
- Мал үржүүлэг, мал эмнэлгийн үйлчилгээ
- Малын ялган тэмдэглэх хэрэгсэл үйлдвэрлэл

Хөнгөн үйлдвэр

- Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Мод модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Арьс ширэн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэл
- Гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Үйлчилгээ

- Ахуйн үйлчилгээний төв /3-аас дээш засвар, үйлчилгээ/

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС 2024 ОНД
ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХ ЧИГЛЭЛ**

- Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хотоос орон нутагт шилжин үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, орон нутагт шилжсэн иргэнийг ажилд авсан үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж;
- Импортыг орлох шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэл;
- Экспортод чиглэсэн кластерын үйлдвэрлэл;
- Баяжуулсан болон органик бүтээгдэхүүн үйлдвэрлэл;
- Инновацийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх;
- Хүнсний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч аж ахуйн нэгж;
- Сахарын агууламж багатай хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлуулж байгаа аж ахуйн нэгж;

Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн
 үйлдвэрийн Сайдын 2024 оны
 01 дүгээр сарын 15-ны өдрийн
 А/18 дугаар тушаалын
 2 дугаар хавсралт

САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ХУВААРЬ

№	Бүс	Аймаг	Санхүүжилтийн хуваарь
1	Баруун бүс	Баян-Өлгий	1,000,000,000
2		Говь-Алтай	1,100,000,000
3		Завхан	1,400,000,000
4		Увс	1,100,000,000
5		Ховд	1,000,000,000
6	Хангайн бүс	Архангай	900,000,000
7		Баянхонгор	1,100,000,000
8		Булган	1,000,000,000
9		Орхон	1,000,000,000
10		Өвөрхангай	900,000,000
11		Хөвсгөл	1,000,000,000
12	Төвийн бүс	Говьсүмбэр	900,000,000
13		Дархан-Уул	1,000,000,000
14		Дорноговь	900,000,000
15		Дундговь	1,000,000,000
16		Өмнөговь	1,000,000,000
17		Сэлэнгэ	900,000,000
18		Төв	900,000,000
19	Зүүн бүс	Дорнод	1,100,000,000
20		Сүхбаатар	1,400,000,000
21		Хэнтий	900,000,000
	21 аймагт		21,500,000,000
22	Улаанбаатар хот		7,500,000,000
	НИЙТ ДҮН		29,000,000,000